УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын 7 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: УВА-2026/148/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| | Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь |
| | Утас:70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn |
| | Аудитын менежер: М.Бат-Амгалан |
| Цахим хуудас: www.audit.mn | Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn |
| | Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн Аудитор: С.Батсайхан |
| Улаангом хот 2026 он | Утас:99459831, Цахим хаяг: shurtkhairkhaniikhishigaudit@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 2

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 6

2.5.1Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв ..... 8

2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Орон нутгийн төсөв ..... 8

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 9

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 9

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 9

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 10

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 11

3.5.1 Төсвийн төлөвлөлт ..... 11

3.5.2 Төсвийн гүйцэтгэл ..... 11

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 13

4.1 Ерөнхий зүйл ..... 13

4.2 Материаллаг байдал ..... 14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 14

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 15

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ..... 15

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 15

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026.02.23 № УВА-2026/148/НА-СТА-ТШЗ
танай ______________ -ны № ______________ -т

УЛААНГОМ СУМЫН
7-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
З.УУГАНБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын 7 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Улаангом сумын 7 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050503

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **243,540,072.41** | **120,509,112.17** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 158,983,922.71 | 24,202,474.67 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 158,983,922.71 | 24,202,474.67 |
| **3121** | **Төгрөг** | 158,983,922.71 | 24,202,474.67 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 158,983,922.71 | 24,202,474.67 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 84,556,149.70 | 96,306,637.50 |
| **351** | **Түүхий эд материал** | 175,615.20 | 176,900.00 |
| 35130 | Эм боох материал | 175,615.20 | 176,900.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 84,380,534.50 | 96,129,737.50 |
| 35420 | Аж ахуйн материал | 55,681,772.00 | 61,343,072.00 |
| 35460 | Хүнсний материал | 7,126,430.00 | 820,750.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 21,572,332.50 | 33,965,915.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,267,889,130.18** | **1,296,002,945.28** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,267,889,130.18 | 1,296,002,945.28 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,145,129,130.18 | 1,173,242,945.28 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,192,494,800.00 | 1,192,494,800.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -125,934,021.18 | -152,475,413.46 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 60,876,890.20 | 86,070,265.68 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -42,293,120.60 | -49,889,185.39 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 95,802,447.88 | 85,905,826.79 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -43,273,332.60 | -33,527,335.58 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,959,250.00 | 49,959,250.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,613,963.52 | -8,405,442.76 |
| 39217 | Ном | 3,110,180.00 | 3,110,180.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 122,760,000.00 | 122,760,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -550,000.00 | -550,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 122,760,000.00 | 122,760,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,511,429,202.59** | **1,416,512,057.45** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **38,253,985.29** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 38,253,985.29 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 38,253,985.29 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 38,253,985.29 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 38,253,985.29 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,511,429,202.59** | **1,378,258,072.16** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,511,429,202.59 | 1,378,258,072.16 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 625,602,587.00 | 625,602,587.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 625,602,587.00 | 625,602,587.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 792,632,701.14 | 662,786,793.20 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 792,632,701.14 | 795,957,923.63 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -133,171,130.43 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 93,193,914.45 | 89,868,691.96 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,511,429,202.59** | **1,416,512,057.45** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,474,054,500.00** | **1,402,470,252.16** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **13,438,300.00** | **74,596,652.16** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 13,438,300.00 | 74,596,652.16 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 00.00 | 67,000,572.16 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 00.00 | 7,596,080.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,460,616,200.00** | **1,327,873,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,323,060,500.00 | 1,190,850,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,323,060,500.00 | 1,190,850,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 137,555,700.00 | 137,022,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 137,555,700.00 | 137,022,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,366,360,172.71** | **1,535,641,382.59** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,366,360,172.71** | **1,535,641,382.59** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,365,128,301.14 | 1,525,695,982.59 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 889,853,473.48 | 994,448,280.49 |
| 210101 | Үндсэн цалин | 541,040,387.57 | 600,463,453.35 |
| 210102 | Нэмэгдэл | 269,526,815.36 | 311,044,812.67 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 21,190,829.50 | 43,533,065.22 |
| 210104 | Урамшуулал | 58,095,441.05 | 39,386,949.25 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 109,509,093.19 | 122,693,737.55 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 76,608,563.21 | 83,413,971.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,859,462.75 | 9,935,646.74 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,400,031.28 | 4,967,823.30 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,928,207.08 | 4,876,790.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,712,828.87 | 19,499,504.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 118,921,073.38 | 171,907,285.29 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,390,083.84 | 12,840,242.69 |
| 210302 | Түлш, халаалт | 87,916,864.54 | 128,559,129.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 20,614,125.00 | 30,507,913.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,221,063.93 | 15,161,867.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,538,850.00 | 4,604,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 460,275.00 | 345,470.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,074,098.93 | 968,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,572,660.00 | 6,562,650.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 19,575,180.00 | 2,680,997.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 135,452,850.00 | 145,357,045.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 171,900.00 | 383,015.20 |
| 210502 | Хоол, хүнс | 135,280,950.00 | 144,974,030.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,008,850.00 | 7,122,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,008,850.00 | 7,122,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,564,800.00 | 1,686,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 568,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,996,800.00 | 1,686,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,307,150.00 | 8,573,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,450,150.00 | 5,330,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,425,000.00 | 3,243,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 56,289,947.16 | 58,745,567.06 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,210,000.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,154,750.00 | 7,910,350.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 44,925,197.16 | 50,835,217.06 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,231,871.57 | 9,945,400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 9,945,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 9,945,300.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,231,871.57 | 100.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,231,871.57 | 100.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **107,694,327.29** | **-133,171,130.43** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 338,279.72 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 338,279.72 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -338,279.72 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **107,356,047.57** | **-133,171,130.43** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,460,616,200.00** | **1,327,873,600.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,460,616,200.00** | **1,327,873,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,323,060,500.00 | 1,190,850,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,323,060,500.00 | 1,190,850,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 137,555,700.00 | 137,022,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 137,555,700.00 | 137,022,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,315,212,180.60** | **1,450,706,588.04** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,315,212,180.60** | **1,450,706,588.04** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,313,980,309.03** | **1,440,761,188.04** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 889,853,473.46 | 994,446,280.49 |
| 210101 | Үндсэн цалин | 541,040,387.57 | 600,483,453.35 |
| 210102 | Нэмэгдэл | 269,526,815.36 | 311,044,812.67 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 21,190,829.50 | 43,533,065.22 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 58,095,441.05 | 39,386,949.25 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **109,509,093.19** | **122,693,737.55** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 76,608,563.21 | 83,413,971.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,859,462.75 | 9,935,646.74 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,400,031.28 | 4,967,823.30 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,928,207.08 | 4,876,790.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,712,828.87 | 19,499,504.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **119,834,978.43** | **133,653,300.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,390,083.84 | 11,353,947.30 |
| 210302 | Түлш, халаалт | 88,830,769.59 | 95,614,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 20,614,125.00 | 26,685,252.70 |
| **2105** | **Норматив зардал** | **137,617,630.00** | **138,668,350.00** |
| 210502 | Хоол, хүнс | 137,617,630.00 | 138,668,350.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,408,850.00 | 3,369,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,408,850.00 | 3,369,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,338,000.00** | **5,298,980.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,338,000.00 | 5,298,980.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 37,418,283.93 | 42,629,140.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,213,983.93 | 31,033,840.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,204,300.00 | 11,595,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,231,871.57** | **9,945,400.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 9,945,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 9,945,300.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1.231.871.57** | **100.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,231,871.57 | 100.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **145,404,019.40** | **-122,832,988.04** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **5,035,500.00** | **11,948,460.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 5,035,500.00 | 11,948,460.00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 5,035,500.00 | 11,948,460.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,035,500.00 | 11,948,460.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-5,035,500.00** | **-11,948,460.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 140,368,519.40 | -134,781,448.04 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 18,615,403.31 | 158,983,922.71 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 158,983,922.71 | 24,202,474.67 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 625,602,587.00 | 15,156,247.96 | -147,293,913.69 | 493,464,921.27 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **625,602,587.00** | **15,156,247.96** | **-147,293,913.69** | **493,464,921.27** |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 164,282,250.81 | 164,282,250.81 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **625,602,587.00** | **93,193,914.45** | **792,632,701.14** | **1,511,429,202.59** |
| **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **625,602,587.00** | **93,193,914.45** | **792,632,701.14** | **1,511,429,202.59** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 3,325,222.49 | 3,325,222.49 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **625,602,587.00** | **93,193,914.45** | **795,957,923.63** | **1,514,754,425.08** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -3,325,222.49 | 00.00 | -3,325,222.49 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -133,171,130.43 | -133,171,130.43 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **625,602,587.00** | **89,868,691.96** | **662,786,793.20** | **1,378,258,072.16** |

**2.5.1.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв** /төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗӨРҮҮ | Хувь |
|---|---|---|---|---|
| **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,342,343,300.00** | **1,325,632,248.04** | **16,711,051.96** | **98.8** |
| **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **1,342,343,300.00** | **1,325,632,248.04** | **16,711,051.96** | **98.8** |
| **Бараа, үйлчилгээний зардал** | **1,332,398,000.00** | **1,315,686,948.04** | **16,711,051.96** | **98.7** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **998,065,700.00** | **994,448,280.49** | **3,617,419.51** | **99.6** |
| Үндсэн цалин | 678,326,100.00 | 600,483,453.35 | 77,842,646.65 | 88.5 |
| Нэмэгдэл | 291,500,900.00 | 311,044,812.67 | (19,543,912.67) | 106.7 |
| Унаа, болон бусад нөхөн олговор | - | 43,533,065.22 | (43,533,065.22) | - |
| Урамшуулал | 28,238,700.00 | 39,386,949.25 | (11,148,249.25) | 139.5 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **124,042,600.00** | **122,693,737.55** | **1,348,862.45** | **98.9** |
| Тэтгэврийн даатгал | 84,120,000.00 | 83,413,971.84 | 706,028.16 | 99.2 |
| Тэтгэмжийн даатгал | 9,980,700.00 | 9,935,646.74 | 45,053.26 | 99.5 |
| ҮОМШӨ ний даатгал | 4,990,300.00 | 4,967,823.30 | 22,476.70 | 99.5 |
| Ажилгүйдлийн даатгал | 4,990,300.00 | 4,876,790.93 | 113,509.07 | 97.7 |
| Эрүүл мэндийн даатгал | 19,961,300.00 | 19,499,504.74 | 461,795.26 | 97.7 |
| **Нормативт зардал** | **150,374,500.00** | **138,668,350.00** | **11,706,150.00** | **92.2** |
| Хоол, хүнс | 150,374,500.00 | 138,668,350.00 | 11,706,150.00 | 92.2 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 7,205,800.00 | 7,205,780.00 | 20.00 | 100.0 |
| Мэдээллийн технологийн зардал | 7,205,800.00 | 7,205,780.00 | 20.00 | 100.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **52,709,400.00** | **52,670,800.00** | **38,600.00** | **99.9** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 41,114,100.00 | 41,075,500.00 | 38,600.00 | 99.9 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,595,300.00 | 11,595,300.00 | - | 100.0 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **9,945,300.00** | **9,945,300.00** | **(0.00)** | **100.0** |
| Бусад урсгал шилжүүлэг | 9,945,300.00 | 9,945,300.00 | (0.00) | 100.0 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 9,945,300.00 | 9,945,300.00 | (0.00) | 100.0 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,342,343,300.00** | **1,190,850,800.00** | **151,492,500.00** | **88.7** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,200,894,400.00** | **1,190,850,800.00** | **10,043,600.00** | **99.2** |
| Улсын төсвөөс санхүүжих | 1,200,894,400.00 | 1,190,850,800.00 | 10,043,600.00 | 99.2 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | **156,983,922.71** | | - |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | **24,202,474.67** | | - |

**2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Орон нутгийн төсөв /төгрөгөөр/**

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗӨРҮҮ | Хувь |
|---|---|---|---|---|
| **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **137,022,800.00** | **137,022,700.00** | **100.00** | **97.4** |
| **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **137,022,800.00** | **137,022,700.00** | **100.00** | **97.4** |
| **Бараа, үйлчилгээний зардал** | **137,022,800.00** | **137,022,700.00** | **100.00** | **97.4** |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **133,653,300.00** | **133,653,300.00** | **-** | **97.3** |
| Гэрэл цахилгаан | 17,588,500.00 | 11,353,947.30 | 6,234,552.70 | 64.6 |
| Түлш, халаалт | 95,614,100.00 | 95,614,100.00 | - | 100.0 |
| Цэвэр, бохир ус | 20,450,700.00 | 26,685,252.70 | (6,234,552.70) | 110.5 |
| **Эд хогшил худалдан авах** | **3,369,500.00** | **3,369,400.00** | **100.00** | **99.9** |
| Урсгал засвар | 3,369,500.00 | 3,369,400.00 | 100.00 | 99.9 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **137,022,800.00** | **137,022,800.00** | **-** | **97.4** |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **137,022,800.00** | **137,022,800.00** | **-** | **97.4** |
| Орон нутгийн төсвөөс | 137,022,800.00 | 137,022,800.00 | - | 97.4 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **0.00** | **(0.00)** | **-** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** | **-** | **-** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын 7 дугаар цэцэрлэг нь нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх зорилготой байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын 7 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын 7 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 94,917.2 мянган төгрөг буюу 6.7 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* — */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | 158,984.00 | 24,202.50 | -134,781.50 |
| АВЛАГА | | | 0.00 |
| УРЬДЧИЛГАА | | | 0.00 |
| БАРАА МАТЕРИАЛ | 84,556.10 | 96,306.60 | 11,750.50 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,267,889.10 | 1,296,002.90 | 28,113.80 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН iii=i+ii** | **1,511,429.20** | **1,416,512.00** | **-94,917.20** |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 38,253.90 | 38,253.90 |
| Засгийн газрын хувь оролцоо | 1,511,429.20 | 1,378,258.10 | -133,171.10 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,511,429.20** | **1,416,512.00** | **-94,917.20** |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 24,202.5 мянган төгрөг болж буурсан нь харилцах дансны үлдэгдлээс зарцуулалт хийсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 96,306.6 мянга төгрөг болж, 11,750.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд аж ахуйн материал 5,661.3 мянга, бусад хангамжийн материал 12,394.9 мянга төгрөгөөр нэмэгдэж хүнсний материал 6,305.7 мянга төгрөг тус тус материалын эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,296,002.9 мянган төгрөг болж 28,113.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд тоног төхөөрөмж 28,310.4 мянга төгрөг, тавилга аж ахуйн эд хогшил 8,063.6 мянга, бусад үндсэн хөрөнгө 44,000.0 мянган төгрөгөөр , элэгдлийн зардал 52,260.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,416,512.0 мянган төгрөг болж 94,917.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны санхүүгийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,212,944.3 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийг 128,559.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд улсын төсвөөс 1,200,894.4 мянга, орон нутгийн төсвөөс 140,718.1 мянга, нийт 1,341,612.5 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн хүрээнд 40 арга хэмжээнд 1,190,850.8 мянган төгрөг улсын төсвөөс, 137,022.8 мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,190,850.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 137,022.8 мянган төгрөг нийт 1,327,873.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, нийт урсгал үйл ажиллагаанд 1,462,655.0 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,462,655.0 мянган төгрөг буюу 111,3 хувьтай байгаа нь урьд оны үлдэгдлээс 134,781.4 мянган төгрөг зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /Улсын төсөв/ /мянган төгрөг/*

| д/д | Хөтөлбөр арга хэмжээ | | төлөвлөгөө | гүйцэтгэл | зөрүү | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | НЭР | | | | |
| 1 | 80233 | Хүүхэд хамгаалал | 2814.3 | 2814.3 | 0 | 100.0 |
| 2 | 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 2584.0 | 2565.0 | -19 | 99.3 |
| 3 | 81807 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 145697.7 | 138668.3 | -7029.4 | 95.2 |
| 4 | 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 5287.2 | 5287.2 | 0 | 100.0 |
| 5 | 81823 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх | 1522.7 | 2265.0 | 742.3 | 148.7 |
| 6 | 81832 | Нүүдлийн бүлэгт хамруулах | | | - | |
| 7 | 81833 | Явуулын багшийн үйлчилгээ | | | - | |
| 8 | 81834 | Боловсролын стандарт, сургалт | 1,002,122.4 | 1,143,233.5 | 141,111.1 | 114.1 |
| 9 | 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 30,822.5 | 30,798.9 | (23.6) | 99.9 |
| **Дүн** | | | **1,190,850.8** | **1,325,632.2** | 134,781.4 | 111.3 |

*Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл / Орон нутгийн төсөв/*

| д/д | | | төлөвлөгөө | гүйцэтгэл | зөрүү | биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | НЭР | | | | |
| 1 | 80111 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 137,022.80 | 137,022.70 | -0.10 | 100.0 |
| **Дүн** | | | **137,022.80** | **137,022.70** | **-0.10** | **100.00** |

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Программ хангамжийн бүртгэл, тайлагнал | 0 | 0 | Тайлант онд программ хангамж худалдан аваагүй байна. |
| 2 | Унаа хоолны хөнгөлөлт, зардлын тариф | 291,500.9 | 43,533.0 | Төрийн албаны тухай хуулийн 61.1.3 Монгол улсын засгийн газрын 2019.01.09-ний өдрийн 6 дугаар тогтоол |
| 3 | Сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал | 0 | 0 | Тайлант онд сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зардал гараагүй байна. |
| 4 | Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал | 0 | 0 | Тайлант онд гадаад томилолтод зардал гараагүй байна. |
| 5 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал | 0 | 0 | Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал гараагүй байна. |
| 6 | Орон тооны цомхотгол | 0 | 0 | Тайлант онд орон тооны цомхтгол хийгдээгүй байна. |
| 7 | Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл | 0 | 0 | Байгуулсан гэрээ болон зардал гараагүй болно. |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улаангом сумын 7 дугаар цэцэрлэг тайлант онд хүнсний материал худалдан авахад тендерийн үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд 48,419.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж

заасны дагуу Улаангом сумын 7 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хооронд Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн аудитор С.Батсайхан гүйцэтгэж, чанарын хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын 7 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Шүрт хайрханы хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,535,641.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 15,356,413.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг төлөвлөлтийн 80.0 хувиар буюу 12,285.1 мянган төгрөгөөр тогтоосныг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улаангом сумын 7 дугаар цэцэрлэг нь тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улаангом сумын 7 дугаар цэцэрлэг нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс 166 мэдээллийг бүрэн мэдээлж,хугацаа хоцорсон 3 мэдээлэл, мэдээлээгүй 2 шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй.

### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,034.4 мянган төгрөгийн зөрчил[1] илэрсэнд төлбөрийн акт тогтоосон.

### 5.1. Төлбөрийн акт

1. Улаангом сумын 7-р цэцэрлэгийн эрхлэгч З.Ууганбаярт ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож 2,034.4 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2-т "Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>** Төлбөрийн акт тогтоосон.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Улаангом сумын 7-р цэцэрлэгийн эрхлэгч З.Уганбаярт ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож 2,034.4 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг илүү олгосон байна. | 1 | 2,034.4 | 1 | 2,034.4 | | | | | | | | |
| Дүн | 1 | 2,034.4 | 1 | 2,034.4 | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

9065565 1525010041

БЭЛТГЭСЭН:

"ШҮРТ ХАЙРХАНЫ ХИШИГ АУДИТ" ХХК-ийн АУДИТОР /С.БАТСАЙХАН/

2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр

УВА-2026/148/НА-СТА-ТШЗ

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2026 оны 02 сарын 25 өдөр | Дугаар 01/09/B2715686 УВА-2026/148/НА-СТА-ТШ3 | Улаангом

## ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улаангом сумын 7-р цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улаангом сумын 7-р цэцэрлэгийн эрхлэгч З.Ууганбаярт ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож 2,034.4 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү олгосон ээлжийн амралтын цалин 2,034,437 (хоёр сая гучин дөрвөн мянга дөрвөн зуун гучин долоо) төгрөгийг төлүүлж, Төрийн сан дахь МХГ-ын орлогын 100150000982 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэхийг Увс аймгийн Боловсролын газрын дарга А.Болормаад хариуцуулав.

---

[1] *Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317*

8525110049

3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөргүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

АУДИТЫН МЕНЕЖЕР М.БАТ-АМГАЛАН

9065555 1525010041

"ШҮРТ ХАЙРХАНЫ ХИШИГ АУДИТ" ХХК-ийн
АУДИТОР С.БАТСАЙХАН